

ЭНЭ МЭДЭЭГ ОДООНООС АШИГЛАЖ БОЛНО.

Хэвлэлийн мэдээ
УРИЛГА

№. 14-14

2014 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

10 дугаар сарын 17-ны өдөр Японы Уламжлалт модон барын арга барилыг хадгалах “Адачи” сангаас “Японы Үкиё-э буюу модон бараар хэвлэсэн зургийн тухай лекц, үзүүлбэр” нэртэй арга хэмжээг зохион байгуулах гэж байна. Уг арга хэмжээний хамтран зохион байгуулагчаар Японы ЭСЯ, ивээн тэтгэгчээр Хаан банк, Япон сан тус тус оролцоно. Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

Хэзээ: 2014 оны 10 сарын 17-ны өдөр, 12 цагт

Хаана: ХААН банкны төв байрны “Red Ger” галерей

Уг арга хэмжээ төлбөргүй бөгөөд нээлттэй тул та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна. Мөн арга хэмжээний үеэр чөлөөтэй сурвалжлага хийх боломжтой.

ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

ЛАВЛАХ УТАС:320777